



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: АРА-2022/28/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор: Т.Байгалмаа Утас: 70333141 Цахим хаяг: Baigalmaa.T@audit.gov.mn Аудитын менежер: Д.Нэргүйбаатар Утас: 70332860 Цахим хаяг: Nerguibaatar.d@audit.gov.mn Аудитор: Г.Цог-Эрдэнэ Утас: 99210906 Цахим хаяг: Tsogerdene.g@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. Аудитын дүгнэлт	
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. Аудитын тайлан	11
3.1 Ерөнхий зүйл	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	13
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан /Local.audit.mn сайтад шивсэн/ ба алдаа зөрчил илрээгүй болно.	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
4. Аудитын илрүүлэлт	14

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ШЕЗ	Шүүхийн Ерөнхий зөвлөл
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
НББТХ	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль



**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс: 976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Ц.ЭРДЭНЭЦОГТ ТАНАА

2022.02.14 № 05
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Архангай аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т.БАЙГАЛМАА



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

№	Үзүүлэлт	/ төгрөгөөр /	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	19,503,065	23,912,105
2	БАРАА МАТЕРИАЛ	19,503,065	23,912,105
3	Хангамжийн материал	19,503,065	23,912,105
4	Бичиг хэргийн материал	851,850	633,600
5	Аж ахуйн материал	17,003,215	22,588,505
6	Сэлбэг хэрэгсэл	112,000	
7	Түлш, шатах тослох материал	840,000	690,000
8	Барилгын засварын материал	696,000	
9	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	141,223,215.77	262,740,443.66
10	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	141,223,215.77	262,740,443.66
11	Биет хөрөнгө	128,306,549.09	249,890,443.6
12	Барилга, байгууламж, орон сууц	70,796,600	70,796,600
13	Хуримтлагдсан элэгдэл	-15,178,613.04	-17,244,923.16
14	Авто-тээврийн хэрэгсэл	77,936,000	93,936,000
15	Хуримтлагдсан элэгдэл	-76,387,200.04	-8,357,733.41
16	Машин тоног төхөөрөмж(компьютер)	194,885,493.91	123,404,057.3
17	Хуримтлагдсан элэгдэл	-159,558,528.14	-48,957,213.45
18	Тавилга, аж ахуйн эд хогшил	104,334,992.04	83,873,282.04
19	Хуримтлагдсан элэгдэл	-68,606,615.64	-47,839,877.72
20	Ном	84,420	280,252
21	Биет бус хөрөнгө	12,916,666.68	12,850,000.06
22	Програм хангамж	1,550,000	1,220,000
23	Хуримтлагдсан элэгдэл	-633,333.32	-369,999.94
24	Бусад биет бус хөрөнгө	12,000,000	12,000,000
25	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	160,726,280.77	286,652,548.66
26	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	160,726,280.77	286,652,548.66
27	Засгийн газрын хувь оролцоо	160,726,280.77	286,652,548.66
28	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	138,635,859.67	138,635,859.67
29	Хуримтлагдсан үр дүн	-47,538,047.87	78,388,220.02
30	Өмнөх үеийн үр дүн	-55,253,646.31	-47,538,047.87
31	Тайлант үеийн үр дүн	7,715,598.44	125,926,267.89
32	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	69,628,468.97	69,628,468.97
33	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	160,726,280.77	286,652,548.66

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

№	Үзүүлэлт	/ төгрөгөөр /	
		Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,005,188,087	1,154,296,858
2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	23,870,787	150,315,658
3	Нийтлэг татварын бус орлого	23,870,787	150,315,658
4	Бусад орлого		74,463,415
5	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	23,036,567	75,333,587
6	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	834,220	518,656
7	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	981,317,300	1,003,981,200
8	Улсын төвлөрсөн төсвөөс	981,317,300	1,003,981,200
9	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	981,317,300	1,003,981,200
10	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	997,472,488.56	1,028,370,590.11
11	УРСГАЛ ЗАРДАЛ	997,472,488.56	1,028,370,590.11
12	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	970,661,579.78	1,014,760,538.14
13	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	750,295,004.89	762,382,007.37
14	Үндсэн цалин	593,331,290.89	601,557,910.99
15	Нэмэгдэл	107,492,071	109,289,692.2
16	Унаа хоолны хөнгөлөлт	24,985,000	24,279,389.58
17	Урамшуулал	24,486,643	27,255,014.6
18	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	95,140,758.88	101,360,321.74
19	Тэтгэврийн даатгал	64,693,308.32	70,475,250.76
20	Тэтгэмжийн даатгал	7,843,583.82	7,848,322.78
21	ҮОМШӨ-ний даатгал	6,058,144.14	6,144,258.18
22	Ажилгүйдлийн даатгал	1,498,096.41	1,531,844.39
23	Эрүүл мэндийн даатгал	15,047,626.19	15,360,645.63
24	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,000,145.44	36,618,983.9
25	Гэрэл, цахилгаан	4,493,764	4,269,448
26	Түлш, халаалт	31,407,481	31,360,681
27	Цэвэр, бохир ус	1,098,900.44	988,854.9
28	Хангамж, бараа материалын зардал	52,008,372	51,029,898.02
29	Бичиг хэрэг	14,768,039	15,829,266
30	Тээвэр, шатахуун	13,787,500	13,750,000
31	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,664,853	11,938,336.02
32	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	270,000	360,000
33	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,517,980	9,152,296
34	Нормативт зардал	118,000	
35	Нормын хувцас, зөөлөн эдлэл	118,000	

Архангай аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

36	Эд хогшил, урсгал засварын зардал	5,723,890	11,540,660
37	Багаж, техник, хэрэгсэл	80,000	
38	Урсгал засвар	5,643,890	11,540,660
39	Томилолт, зочны зардал	4,012,050	4,584,207
40	Дотоод албан томилолт	4,012,050	4,584,207
41	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,099,780	5,165,686
42	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,271,948	4,126,010
43	Даатгалын үйлчилгээ	705,340	694,450
44	Тээврийн хэрэгслийн татвар	48,492	108,046
45	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000	22,000
46	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		185,900
47	Газрын төлбөр	52,000	29,280
48	Бараа үйлчилгээний бусад зардал	22,263,578.57	42,078,774.11
49	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	22,263,578.57	42,078,774.11
50	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,810,908.78	13,610,051.97
51	Бусад урсгал шилжүүлэг	3,999,950	1,600,000
52	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,999,950	1,600,000
53	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	22,810,958.78	12,010,051.97
54	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,810,958.78	12,010,051.97
55	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	7,715,598.44	125,926,267.89
56	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	7,715,598.44	125,926,267.89

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

№	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/ төгрөгөөр /
					Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	138,635,859.67	69,628,468.97	-55,253,646.31	153,010,682.33
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	138,635,859.67	69,628,468.97	-55,253,646.31	153,010,682.33
3	Тайлант үеийн үр дүн			7,715,598.44	7,715,598.44
4	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	138,635,859.67	69,628,468.97	-47,538,047.87	160,726,280.77
5	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	138,635,859.67	69,628,468.97	-47,538,047.87	160,726,280.77
6	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	138,635,859.67	69,628,468.97	-47,538,047.87	160,726,280.77
7	Тайлант үеийн үр дүн			125,926,267.89	125,926,267.89
8	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	138,635,859.67	69,628,468.97	78,388,220.02	286,652,548.66

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

№	Үзүүлэлт	/ төгрөгөөр /	
		өмнөх он	тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	981,317,300	1,003,981,200
2	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	981,317,300	1,003,981,200
3	Улсын төвлөрсөн төсвөөс	981,317,300	1,003,981,200
4	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	981,317,300	1,003,981,200
5	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	974,634,300	990,182,200
6	УРСГАЛ ЗАРДАЛ	974,634,300	990,182,200
7	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	947,823,391.22	976,172,148.03
8	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	750,295,004.89	762,382,007.37
9	Үндсэн цалин	593,331,290.89	601,557,910.99
10	Нэмэгдэл	107,492,071	109,289,692.2
11	Унаа хоолны хөнгөлөлт	24,985,000	24,279,389.58
12	Урамшуулал	24,486,643	27,255,014.6
13	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	95,140,758.89	101,360,321.74
14	Тэтгэврийн даатгал	64,693,308.33	70,475,250.76
15	Тэтгэмжийн даатгал	7,843,583.82	7,848,322.78
16	ҮОМШӨ-ний даатгал	6,058,144.14	6,144,258.18
17	Ажилгүйдлийн даатгал	1,498,096.41	1,531,844.39
18	Эрүүл мэндийн даатгал	15,047,626.19	15,360,645.63
19	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,000,145.44	36,618,983.9
20	Гэрэл, цахилгаан	4,493,764	4,269,448
21	Түлш, халаалт	31,407,481	31,360,681
22	Цэвэр, бохир ус	1,098,900.44	988,854.9
23	Хангамж, бараа материалын зардал	48,170,862	47,569,442.02

Архангай аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

24	Бичиг хэрэг	14,409,869	15,368,200
25	Тээвэр, шатахуун	13,672,500	13,600,000
26	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,664,853	11,938,336.02
27	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	838,400	1,013,000
28	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,585,240	5,649,906
29	Нормативт зардал	797,900	800,000
30	Нормын хувцас, зөөлөн эдлэл	797,900	800,000
31	Эд хогшил, урсгал засварын зардал	8,306,890	17,691,500
32	Багаж, техник, хэрэгсэл	623,000	8,494,440
33	Урсгал засвар	7,683,890	9,197,060
34	Томилолт, зочны зардал	4,012,050	4,584,207
35	Дотоод албан томилолт	4,012,050	4,584,207
36	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,099,780	5,165,686
37	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,271,948	4,126,010
38	Даатгалын үйлчилгээ	705,340	694,450
39	Тээврийн хэрэгслийн татвар	48,492	108,046
40	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000	22,000
41	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		185,900
42	Газрын төлбөр	52,000	29,280
43	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,810,908.78	14,010,051.97
44	Бусад урсгал шилжүүлэг	3,999,950	2,000,000
45	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,999,950	2,000,000
46	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	22,810,958.78	12,010,051.97
47	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,810,958.78	12,010,051.97
48	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	6,683,000	13,799,000
49	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	6,683,000	13,799,000
50	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6,683,000	13,799,000
51	Дотоод эх үүсвэрээр	6,683,000	13,799,000
52	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	6,683,000	13,799,000
53	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-6,683,000	-13,799,000
54	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)		
	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	/ төгрөгөөр /
			Гүйцэтгэл
1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,003,981,200	991,971,148.03
2	УРСГАЛ ЗАРДАЛ	1,003,981,200	991,971,148.03
3	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,001,981,200	989,971,148.03
4	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	764,819,300	762,382,007.37
5	Үндсэн цалин	633,965,900	601,557,910.99
6	Нэмэгдэл	91,338,900	109,289,692.2
7	Унаа хоолны хөнгөлөлт	26,316,600	24,279,389.58
8	Урамшуулал	13,197,900	27,255,014.6
9	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	102,004,200	101,360,321.74
10	Тэтгэврийн даатгал	71,801,600	70,475,250.76
11	Тэтгэмжийн даатгал	7,550,700	7,848,322.78
12	ҮОМШӨ-ний даатгал	6,040,500	6,144,258.18
13	Ажилгүйдлийн даатгал	1,510,100	1,531,844.39
14	Эрүүл мэндийн даатгал	15,101,300	15,360,645.63
15	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,767,600	36,618,983.9
16	Гэрэл, цахилгаан	4,743,700	4,269,448
17	Түлш, халаалт	31,360,900	31,360,681
18	Цэвэр, бохир ус	1,663,000	988,854.9
19	Хангамж, бараа материалын зардал	52,390,400	47,569,442.02
20	Бичиг хэрэг	17,084,000	15,368,200
21	Тээвэр, шатахуун	15,904,000	13,600,000
22	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	12,712,400	11,938,336.02
23	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,040,000	1,013,000
24	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,650,000	5,649,906
25	Нормативт зардал	800,000	800,000
26	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800,000	800,000
27	Эд хогшил, урсгал засварын зардал	31,500,000	31,490,500
28	Багаж, техник, хэрэгсэл	20,500,000	20,493,440
29	Урсгал засвар	11,000,000	10,997,060
30	Томилолт, зочны зардал	5,419,800	4,584,207
31	Дотоод албан томилолт	5,419,800	4,584,207
32	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,279,900	5,165,686
33	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,851,400	4,126,010
34	Даатгалын үйлчилгээ	708,000	694,450

Архангай аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

35	Тээврийн хэрэгслийн татвар	282,000	108,046
36	Тээврийн хэрэгслийн оношлогоо	40,000	22,000
37	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	346,500	185,900
38	Газрын төлбөр	52,000	29,280
39	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,000,000	2,000,000
40	Бусад урсгал шилжүүлэг	2,000,000	2,000,000
41	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000	2,000,000
42	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,003,981,200	991,971,148.03
43	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,003,981,200	991,971,148.03
44	Улсын төсвөөс санхүүжих	1,003,981,200	991,971,148.03
45	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	81	81
46	БАЙГУУЛЛАГЫН ТОО	5	5
47	Төсвийн байгууллага	5	5
48	АЖИЛЛАГСАДЫН ТОО	38	38
49	Удирдах ажилтан	5	5
50	Гүйцэтгэх ажилтан	29	29
51	Үйлчлэх ажилтан	4	4
52	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	38	38
53	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	15	15
54	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	10	10
55	Шүүгч	13	13

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Архангай аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Цог-Эрдэнэ гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Архангай аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25 -ны өдрийн 25 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Архангай аймаг дахь Шүүхийн тамгын газар нь Шүүхийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасны дагуу харьяалах нутаг дэвсгэртээ Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, Үндсэн хуульт байгууллыг бататган бэхжүүлж, хамгаалах, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх, хууль дээдлэх, шударга ёсыг бэхжүүлэх, шударга шүүхээр шүүлгэх иргэний эрхийг хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн харьяа байгууллага юм.

Тус байгууллага нь тайлант онд *“Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт, арга хэмжээний хүрээнд иргэдэд хүргэх шүүхийн үйлчилгээ, нээлттэй байдлын мэдээллийн цахим болон биет орчинг сайжруулах, чанар, үр нөлөөг нэмэгдүүлэх”* гэсэн зорилт тавин ажилласан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд Шүүхийн Ерөнхий зөвлөлөөс төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар аудитад ашиглах, шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Архангай аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байх тул хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 1,003.9 сая төгрөгөөс 1 хувиар буюу 10.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 70 хувиар буюу 6.9 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн эхний үлдэгдэл 125.9 сая төгрөгөөр буюу 78.3 хувиар өсч материаллаг өөрчлөлт гарсан нь бараа материал, үндсэн хөрөнгийн дансууд байна.

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	Хувь
Бараа материал	19.5	23.9	4.4	22.6
Үндсэн хөрөнгө	141.2	262.7	121.5	86.0
Нийт хөрөнгө	160.7	286.7	125.9	78.3
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	160.7	286.7	125.9	78.3
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	160.7	286.7	125.9	78.3

3.5.1. Бараа материалын эхний үлдэгдэл 22.6 хувиар өссөн байна.

Бараа материалын данс нь 19.5 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 51.9 сая төгрөг, бусад байгууллагаас үнэ төлбөргүй хүлээн авсан 0.5 сая төгрөг нийт 52.4 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд 48.0 сая төгрөгийн зарцуулалт гарч, 23.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

3.5.2. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 86 хувиар өссөн байна.

Үндсэн хөрөнгө данс нь 141.2 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 13.8 сая төгрөг, бусад байгууллагаас үнэ төлбөргүй хүлээн авсан 75.3 сая төгрөг, үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгасан 74.4 сая төгрөг нийт 163.6 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант хугацаанд байгуулсан 42.0 сая төгрөгийн элэгдлээр буурч оны эцэст 262.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

3.5.3. Цэвэр хөрөнгө өмчийн дүн өссөн нь тайлант хугацааны үр дүн 125.9 сая төгрөгөөр өссөнтэй холбоотой.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 1,073.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлжээ.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 92.5 сая төгрөгөөр бууруулж, зардлыг 981.3 сая төгрөгөөр хянаж баталсан байна. Харин тайлант онд батлагдсан төсвийн дүнг 2.3 хувиар буюу 1,003.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгожээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагч 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 1,003.9 сая төгрөгийн төсөв батлагдсан. Гүйцэтгэлээр санхүүжилтийг бүрэн авч, 991.9 сая төгрөгийг зарцуулж, 12.0 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж, тайлант онд батлагдсан төсвийг 1.2%-иар хэмнэж төсвийн хэмнэлтийг бий болгосон байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Архангай аймаг дахь Шүүхийн тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд орлого төвлөрөөгүй байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлангийн жилд Монгол Улсын Их Хурлын 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдаж, 2021 оны 03 дугаар сарын 01-ны өдрөөс эхлэн мөрдөж эхэлсэн.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 4 үндсэн зорилтын хүрээнд 33 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 91 хувьтай байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд 1,003.9 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөснөөс хэрэгжилт 98.8 хувийн биелэлттэй байна.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэллээ. Үүнд:

1. Тус байгууллага нь Төрийн албаны тухай хуулийн 13.1-д заасан Төрийн тусгай чиг үүргийн байгууллага тул төсвийн хэмнэлтийн талаарх “Судалгаа №1 маягтыг гаргах шаардлагагүй байна.
2. Суудлын автомашин ашиглалтын хувьд: Ланд круйзер /Land Cruiser/ 150 Prado маркийн 2013 онд үйлдвэрлэгдсэн 30.0 сая төгрөгийн анхны өртөг бүхий, Рено

дастер маркийн 2021 онд үйлдвэрлэгдсэн 62.0 сая төгрөгийн анхны өртөг бүхий 2 автомашинтай бөгөөд шатахууны зардалд 8.5 сая төгрөгийг зарцуулсан, орон тооны жолоочтой, жолоочийн цалинд 10.9 сая төгрөгийг олгожээ.

Харин бусад судалгаанд холбогдох мэдээлэлгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан /Local.audit.mn сайтад шивсэн/ ба алдаа зөрчил илрээгүй болно.

Энэ нь Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжтой нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Архангай аймаг дахь Шүүхийн тамгын газар нь тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих 147 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийгдээгүй зөрчил илэрсэнд дотоод хяналтыг тогтмол хэрэгжүүлж үр дүнг тооцож ажиллах зөвлөмж хүргүүлснийг 100 хувь хэрэгжүүлж ажилласан байна.

Мөн шилэн дансны цахим системд байршуулвал зохих 7 мэдээллийг хугацаа хоцроосон, нягтлан бодогчийн мэдээллийг шинэчлээгүй, тухайн жилд гарсан төсөв өмчтэй холбоотой 28.4 сая төгрөгийн 11 тушаал шийдвэрийг журмын дагуу системд байршуулаагүйг нөхөн байршуулах, зөрчлийг таслан зогсоох хугацаатай албан шаардлага хүргүүлж биелэлтийг хангуулсан.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт	
	Тоо	Дүн	Тоо	Дүн
Албан шаардлага	1	28.4	1	28.4
Зөвлөмж	1	-	1	-
Нийт дүн	2	28.4	2	28.4

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Шүүхийн тамгын газрын 2021 оны тайлангийн жилд Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбоотойгоор шүүгч, шүүгчийн туслах, бусад холбогдох албан тушаалтны цалин хөлс нэмэгдэж байгаа тул дараагийн аудитаар цалин хөлс, нэмэгдлийг анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар алдаа зөрчил илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.